



Canada

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ХӨТӨЧ

Canada Энэхүү хөтчийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Канадын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газартай хамтран хэрэгжүүлж буй “Жендэрийн мэдрэмжтэй, сайжирч хөгжсөн шүүхийн тогтолцооны үр шимийг Монгол Улсын иргэд хүртэх нь” техникийн туслалцааны түншлэлийн хүрээнд боловсруулж, Канадын Глобал Аффэрс байгууллагын дэмжлэгтэйгээр хэвлэв.

Агуулга

Удиртгал.....	6
Нэг. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ.....	8
Зарчим	8
Тайлбар.....	8
Хоёр. ИТГЭЛ БОЛОН ХҮНДЛЭЛ ХҮЛЭЭСЭН БАЙДАЛ	12
Зарчим	12
Тайлбар.....	13
Гурав. УР ЧАДВАР, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛТЭЙ БАЙДАЛ	18
Зарчим.....	18
Тайлбар	19
Дөрөв. ТЭГШ БАЙДАЛ	21
Зарчим.....	21
Тайлбар	21
Тав. ТӨВИЙГ САХИХ БАЙДАЛ	24
Зарчим	24
Тайлбар.....	25

Өмнөх үг

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “I үе шат (2021-2030):** 3.Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө, **II үе шат (2031-2040):** Иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болно, **III үе шат (2041-2050):** Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн байна.” гэж тусгасан бөгөөд энэ бол Шүүх эрх мэдлийн хөгжлийн үе шаттайгаар хүрэх түвшин, зорьж хангах зорилго юм.

Хариуцлагатай, иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн, иргэн төвтэй шүүх эрх мэдлийг эх орондоо үе шаттайгаар төлөвшүүлэхийн хамгийн чухал асуудал нь шүүгч нэг бүр ёс зүйн хувьд ямар ч ашиг сонирхлын зөрчилгүй, хэн нэгнээс бүрэн хараат бус бөгөөд хэрэг маргааныг зөвхөн төвийг сахиж шийдвэрлэх нөхцөлийг хууль эрх зүйн хүрээнд бүрдүүлж, шүүгчдийн шударга ажиллах соёлыг төлөвшүүлэх явдал юм. Шүүх эрх мэдэл бие даасан, хууль дээдлэх ёсонд үнэнч гэдгийг монголын ард түмэн хүлээн зөвшөөрч, шударга ёсонд итгэх итгэлээр шүүхийг хүндэтгэн, итгэл найдвараа эргэлзээгүй хүлээлгэх цагийг авчрах эзэд нь чухамдаа шүүгч нар билээ.

Энэхүү эрхэм чухал үүрэг хариуцлагыг хүлээж буй нийт шүүгч нартаа Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо хамтран энэхүү “Шүүгчийн ёс зүйн хөтөч”-ийг анхлан боловсруулж, ёс зүйн боловсрол, хөгжлийн хэрэгцээнд зориулж өргөн барьж байна.

Канад Улсын Шүүхийн зөвлөл 1998 онд “Шүүгчид зориулсан ёс зүйн зарчмууд” гэсэн бэсрэг гарын авлагыг анхлан боловсруулж шүүгч нарынхаа гар дээр тавьсан байна. Түүнээс хойш шүүгч нар

ёс зүйн хэм хэмжээг нэг мөр ойлголттойгоор дагаж мөрдөх талаар ихээхэн ахиц гарч, шүүгч нарын дунд ёс зүйн талаар зөвлөх зохион байгуулалт хийн өөр хоорондоо зөвлөж туслах соёл төлөвшиж, шүүхэд итгэх олон нийтийн итгэл дээшилж шүүх эрх мэдлийн салбарт томоохон дэвшил гарахад тэрхүү гарын авлага онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Өөрийн орны шүүх эрх мэдлийн хөгжилд энэ туршлагыг нэвтрүүлэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо хамтран Канад Улсын Холбооны шүүхийн хэрэг эрхлэх газартай 2022 оноос “Жендэрийн мэдрэмжтэй, сайжирч хөгжсөн шүүхийн тогтолцооны үр шимийг Монгол Улсын иргэд хүртэх нь” төслийг хэрэгжүүлж байгаа юм. Уг төслийн хүрээнд Канад Улсын шүүгчид зориулсан ёс зүйн зарчмуудад үндэслэн энэхүү “Шүүгчийн ёс зүйн хөтөч”-ийг боловсруулсан болно.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл бэхжиж, иргэн төвтэй шүүхийг төлөвшүүлэх үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН САХИЛГЫН
ХОРОО

Удиртгал

1. Шүүгчийн ёс зүйн хөтөч нь шүүгчдэд ёс зүйн чиг баримжаа болох зорилготой. Энэ агуулгын хүрээнд шүүгч байхын утга учрыг илэрхийлсэн алсын хараа, үнэт зүйлсийг тусгасан болно.

Олон улсын хэмжээнд шүүгчийн ёс зүйн үнэлэмжийг хараат бус, итгэл хүлээсэн, хичээл зүтгэлтэй, цогц чадамжтай, адил тэгш хандлагатай, төвийг сахисан байх шинжүүдийн нийлбэрээр тодорхойлдог жишиг нэгэнтээ тогтжээ.

Шударга ёсыг хэвшүүлэх, хууль дээдлэх зарчмыг бэхжүүлэхэд шүүгчийн зүгээс ёс зүйн шаардлагыг дээд зэргээр баримтлахын учир шалтгааныг шүүгчид болон энгийн хүмүүсийн аль алинд нь ойлгуулахад хөтчийн ач холбогдол оршино.

2. Шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал бодитой хэрэгжих нь Монгол Улсад ардчилсан засаглал, шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж хэвшүүлэхэд тулгуур болохын зэрэгцээ хүн бүрийн эдэлбэл зохих эрхийн үндсэн баталгаа болох ач холбогдолтой.

Хүн бүр төвийг сахисан, цогц чадамжтай, итгэл хүндлэл хүлээсэн шүүгчээр үйлчлүүлэх эрхтэй. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй шүүгч албан үүргээ олон нийтийн итгэлийг бүрэн хүлээхийн төлөө хэрэгжүүлэх учиртай. Үүний тулд шүүгч албан ажил болон хувийн амьдралынхаа хүрээнд хэвшүүлэн тогтоож, хүрвэл зохих ёс зүйн тогтсон стандартыг олон улсын болон үндэсний эрх зүйн шаардлагыг эш үндэс болгон энд тусгасан болно.

Энэхүү хөтчид чиг баримжаа болгон тусгасан суурь ойлголтууд нь дэлхий нийтийн шүүх эрх мэдлийн хэмжээнд зонхилох шинжтэй хэвшиж тогтсон боловч олон нийтийн хүсэл хүлээлт, нийгмийн хөгжил дэвшлийн явцад тэдгээрийг тухайн үеийн нөхцөл байдалд нийцүүлэн дэлгэрүүлж тайлбарлах боломжтой.

3. Шүүгч хэрэг, эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ гаднын дарамт шахалт, нөлөөллөөс ангид, хэн нэгнээс айдасгүйгээр, төвийг сахиж, зөвхөн нотлох баримтад тулгуурлаж, хууль ёсны хүрээнд шударгаар шийдвэрлэх шаардлагатай бөгөөд тэр ёсоор ажиллаж байгааг нь бусад хүмүүс ойлгохоор байх учиртай.

Ёс зүйн хөтчийн аль ч хэсэг нь шүүгчийн хараат бус байдлыг аливаа хэлбэрээр хязгаарлахгүй. Шүүгч хараат бус байдлаа өөрийн албаны эрх хэмжээг бэхжүүлэхийн тулд бус, харин аливаа хүний хэрэг, эрх зүйн маргаанаа төвийг сахисан, хараат бус шүүгчид хандан шударгаар шийдвэрлүүлэх эрхийг Үндсэн хуулиар тунхаглан баталгаажуулсан хэмжээнд хангаж, хамгаалах үүрэгтэй.

4. Шүүгчийн ёс зүйн хөтчид тусгасан ойлголтууд нь шүүгчийн зорилгоо болгож хүрэх ёстой ёс зүйн зайлшгүй шаардлагыг илэрхийлэх бөгөөд ёс зүйн наад захын хэм хэмжээг тогтоосон дүрэм биш юм.

Хөтөч нь зөвлөмжийн чанартай бөгөөд (I) шүүгчийн хэвшүүлбэл зохих жишиг зан үйлийг тодорхойлох, (II) мэргэжлийн буюу ёс зүйн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шүүгчид дэмжлэг болох, (III) олон нийт шүүгчийн ёс зүйн шаардлагын талаар мэдлэг, ойлголттой болоход туслах зорилготой.

Энэхүү хөтөч нь ёс зүйн асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай санал зөрөлдөөнийг шийдвэрлэх, эсхүл эдгээр ойлголтоос өөр байгаа нь аливаад буруутгагдаж шийтгэл хүлээх агуулгагүй.

Ёс зүйн хөтчийг тухайн нөхцөл байдалд тохируулж, шүүгчийн хараат бус байдлын болон эрх зүйн нийтлэг зарчим, шаардлага зэрэгт нийцүүлэн хэрэглэх боломжтой. Тиймээс шүүгч албан үүргээ хэрэгжүүлэхэд болон хувийн амьдралд нь тулгарч болох ёс зүйн асуудлуудыг хөтчид бүрэн гүйцэд, нэг бүрчлэн тусгаагүй гэдгийг тодотгон тэмдэглэж байна.

Нэг. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

Агуулга

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь хуулийн хүрээнд шударга ёсыг тогтооход онцгой ач холбогдолтой.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бодит байдлаар хэрэгжүүлэх эцсийн үр дүн нь зөвхөн шүүгчээс шалтгаална.

Зарчим

1. Шүүгч шүүн таслах ажиллагааг хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байж, хараат бусаар хэрэгжүүлэх үүрэгтэй.
2. Шүүгч шүүхийн шийдвэрт нөлөөлөх аливаа зүй бус оролдлоготой эвлэрэх ёсгүй.
3. Шүүгч ёс зүйн өндөр шаардлагыг хангаж байгаагаа үлгэрлэн харуулах замаар шүүхийн бие даасан байдалд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлнэ.
4. Шүүгч шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн тогтолцоо, захиргаа, зохион байгуулалтын шинжтэй аливаа баталгаа, үйл ажиллагааг тууштай дэмжих ёстой.

Тайлбар

Нийтлэг зүйл

1.1. Шүүгчийн хараат бус байдал гэдэгт шүүгч өөрт хуваарилагдсан хэргийг хуульд нийцүүлэн өөрийн дотоод итгэлээр бусдын болон хөндлөнгийн ямар нэгэн оролцоогүйгээр хянан шийдвэрлэх эрх чөлөө, үүрэг, хариуцлагын нэгдлийг ойлгоно. Шүүгчийн хараат бус байдлын баталгаа нь шүүгч албан үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн болон гаднын зохисгүй нөлөөнд өртөхгүй, автахгүй байх агуулгатай. Шүүгчийн хараат бус байдал бол шүүгчээр ажиллаж байгаа хувь хүний хувьдаа эдэлдэг эрх биш бөгөөд шүүх төвийг сахиж ажиллах, Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг бодитой эдлүүлэхийн үндсэн суурь ойлголт юм.

1.2. Шүүгч аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ бусдын эрх болон үүргийг хууль ёсны эсэхийг нь тодорхойлж дүгнэдэг. Шүүгч шийдвэрээ хуульд бүрнээ нийцсэн байдлаар гаргаж байгаа эсэхээс шүүхэд итгэх иргэдийн итгэл хамаарна.

1.3. Шүүгчийн хараат бус байдал нь шүүхийн чиг үүргийг зохих ёсоор хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэшсэн байдал, хууль тайлбарлан хэрэглэх чадвар, сэтгэл зүйн байдал, хандлагаар тодорхойлогдоно. Шүүгчийн хараат бус байдал нь шүүхээс шударга шийдвэр гаргах үндсэн суурь болно. Шүүгчид тавигдах хамгийн чухал шалгуур бол хараат бусаар, шударга шийдвэр гаргах чадвар юм. Шүүгч ямар ч айдасгүйгээр, хэн нэгэнд давуу байдал олгохгүйгээр, шийдвэр нь олон нийтэд таалагдах эсэхээс үл хамааран хуулийг нэг мөр хэрэгжүүлэх ёстой. Энэ нь хууль дээдлэх зарчмын гол хүчин зүйл бөгөөд шүүгчийн хараат бус байдал энэ арга замаар хангагдана.

1.4. Шүүгчийн хараат бус байдал нь аливаа шийдвэрийг гаднын нөлөөгүйгээр гаргах, хувь хүн болон олон нийтийн зүгээс шүүхэд итгэх итгэлийг хадгалахын үндсэн суурь юм. Шүүгчийн хараат бус байдлын бүрдэл шинжийг хадгалах нь шүүгчийн шударга байдлын талаарх олон нийтийн ойлголтод нэн чухал ач холбогдолтой. Энэ утгаараа шүүгчийн хараат бус байдал бол шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хангах үндсэн

зорилгод хүрэх гол хэрэгсэл болно. Шүүгчийн хараат бус байдал нь шүүгч өөрөө үнэхээр шударга байх, түүнийг шударга гэж бусдын зүгээс ойлгох баталгаа болдог.

1.5. Шүүгч шүүхийн бие даасан байдлыг зөвхөн өөрийн тусын тулд биш, харин бүх хүмүүсийн эрх ашгийн төлөө хамгаалж байх ёстой. Шүүгчийн хараат бус байдлыг шүүгчээр ажиллаж байгаа хүн зөвхөн өөртөө хамаатуулах нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулах эрсдэлд хүргэнэ.

1.6. Шүүхийн чиг үүрэг, шүүгчийн хараат бус байдлын талаар олон нийтэд мэдээлэл өгч байх нь шүүхийн үүрэг болно. Шүүгчийн хараат бус байдлын үндсэн ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд шүүгч хуульд захирагдан шударгаар ажиллах нь олон нийтийн ашиг сонирхолд нийцнэ.

Зохисгүй нөлөөллөөс зайлсхийх, автахгүй байх

2.1. Шүүгч шүүхийн хараат бус байдалд нөлөөлж болох хэн нэгэнтэй харилцахаас зайлсхийх ёстой. Шүүгч шүүхийн шийдвэрт

нөлөөлөх зүй бус оролдлогыг хүлцэх ёсгүй. Шүүхийн шийдвэрт нөлөөлөх зорилготой аливаа харилцаа нь зөвхөн шүүн таслах үйл ажиллагааны хүрээгээр хязгаарлагдана.

2.2. Шүүгч олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулсан аливаа нөлөөллөөс ангид байх ёстой. Үүний тулд олон нийтийн цахим сүлжээнд хэрэг, маргаантай холбоотойгоор оруулсан аливаа асуудлын талаар байр сууриа илэрхийлэхгүй байх, тэр тухайд дэмжих, шүүмжлэх зэргээр байр суурь илэрхийлсэн гэх ойлголтыг бусдад төрүүлэхүйц ямар нэгэн үйлдэл хийхгүй байхад анхаарах хэрэгтэй. Олон нийтийн цахим сүлжээнд шүүгч оролцсон аливаа үйлдэл нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулахааргүй байх ёстой.

Олон нийтийн итгэл

3.1. Шүүгчийн хараат бус байдал, шүүгчийн ёс зүй нь харилцан нягт уялдаатай. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах гол тулгуур болох шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхийн тулд шүүгч ёс зүйн хэм хэмжээг албаны болон хувийн

амьдралдаа чанд даган мөрдөж байгаагаа өөрийн биеэр ямагт үлгэрлэнэ.

Шүүх эрх мэдлийн байгууллагын болон шүүхийн захиргааны бие даасан байдал

4.1. Шүүхийн шийдвэрийг хуулийн дагуу шударгаар гаргахад нөлөөлөх гэсэн аливаа оролдлогоос шүүгч ба шүүхийг хамгаалсан бүтэцтэй байснаар шүүгчийн хараат бус байдал хангагдана. Шүүгчийн бүрэн эрхийн баталгааг хангахад чиглэгдсэн хараат бус бүтэцтэй байж, тэдний цалин хөлсийг хуульд заасан журмаар тогтоодог, аливаа шийтгэлээс айх айдасгүй, шагнал, урамшууллын хамааралгүй байлгах нь шударга ёсыг тогтооход учрах саад тотгорыг арилгах агуулгатай. Түүнчлэн

шүүгчийг гаргасан шийдвэрийнх нь төлөө аливаа хариуцлагад татахгүй байх баталгааг бүрдүүлсэн байна.

4.2. Шүүгчийн хараат бус байдлын зарчмыг хангахын тулд шүүгчийн мэргэшлийг дээшлүүлэх ажлыг шүүх эрх мэдлийн байгууллага өөрөө удирдаж зохион байгуулна.

4.3. Шүүхийг тогтолцооны түвшинд улс төрийн болон бусад зохисгүй нөлөөллөөс ангид байлгахын тулд шүүхийн бие даасан байдал хангалттай баталгаатай байх учиртай.

4.4. Шүүх эрх мэдлийг тогтолцооны болон захиргааны үйл ажиллагааны аль ч байдлаар бие даасан байдлыг нь алдагдуулах үр дагаварт хүргэж болзошгүй аливаа өөрчлөлтийн санаачилгад сэрэмжтэй байх ёстой.

Хоёр. ИТГЭЛ БОЛОН ХҮНДЛЭЛ ХҮЛЭЭСЭН БАЙДАЛ

Агуулга

Шүүгч болон шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалж, бэхжүүлэхийн тулд шүүгч өөрийнхөө зан үйлийг бусдын итгэл, хүндлэл хүлээх байдалд нийцүүлж удирдана.

Зарчим

1. Шүүгч шүүх хуралдааны танхимд болон бусад орчинд ёс зүйн хэм хэмжээ, хууль ёсыг чанд баримтлах ба энэ байдал нь энгийн ямар ч хүнд харагдаж, ойлгогдохоор байвал зохино.
2. Шүүгч шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн нууц мэдээллийг задруулахгүй, албан үүргээ биелүүлэхээс бусад

зорилгоор ашиглахгүй байх ёстой.

3. Шүүгч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүн болгонтой эелдэг, хүндэтгэлтэй байдлаар харьцана.

4. Шүүхэд хандах, шүүн таслах ажиллагаанд тэгш оролцох боломжийг хүн бүрд тэгш олгоход шүүгч дэмжлэг үзүүлж ажиллана. Шүүгч талуудад адил хүндэтгэл үзүүлж, тэгш шударгаар хандах ба тэдний адил, тэгш оролцоог хангах үүрэгтэй.

5. Шүүгч эрх мэдлээ аливаа хэлбэрээр урвуулан ашиглах, дарамт шахалт учруулах хэрэгсэл болгож болохгүй.

6. Шүүгч өөрийн албан тушаалын нэр хүнд, эрх зүйн

байдлыг өөрийн болон бусдын хувийн ашиг сонирхолд ашиглахаас ангид байж бусад шүүгч ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхөд нь дэмжиж тусалдаг байна.

Тайлбар

Нийтлэг зүйл

1.1. Үр нөлөөтэй шүүхийн тогтолцоо болон хууль дээдлэх ёсны үндсэн шалгуур нь шүүхэд итгэх олон нийтийн итгэл юм. Шүүгчийн албан тушаалыг хашиж буй шүүгч энэ тогтолцоонд үлэмж хэмжээний итгэл найдвар, хариуцлага хүлээдэг. Шүүгч шүүхэд болон шүүхээс гадна өндөр ёс зүйтэй гэдгээ батлан харуулах нь хувь шүүгчид итгэх бусдын итгэл, хүндлэлийг төрүүлэх төдийгүй шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой. Ийм учраас бусадтай дээд зэргээр хүнлэг харьцах, зохистой байдлаар биеэ авч явах шаардлага шүүгчид зүй ёсоор тавигдана.

1.2. Шүүгчийн ёс зүйд итгэхийг хүссэн олон нийтийн төсөөлөл нэн өндөр байдаг. Бусад хүний хувьд уучлан хүлээн зөвшөөрч

болох зүйлс ч шүүгчийн хувьд бол зохисгүйд тооцогддог онцлогийг шүүгч ямагт анхаарах ёстой. Иймд шүүгч олон нийтийн итгэлийн төсөөлөлд харшлах аливаа зан үйлээс ямагт болгоомжлон зайлсхийвэл зохино.

Хувийн амьдрал дахь зан үйл

1.3. Шүүгчийн ёс зүйд олон нийтийн итгэл төрөх үйл явц зөвхөн шүүхийн ажил хэргийн орчноор хязгаарлагдахгүй. Шүүгч бусад орчинд, хувийн амьдралдаа ч хууль ёсонд үнэнч, ёс зүйн зохистой зан үйл баримталдаг гэдгээ бусдад үлгэрлэн харуулж, зохисгүй зан үйлээс өөрийгөө ямагт болгоомжлон сэрэмжилж байх ёстой.

1.4. Шүүгчийн албан тушаалд томилогдсон нь шүүгчийг орчин тойрноос нь хязгаарлаж байгаа явдал биш бөгөөд шүүгч нийгмийн амьдралд хэвийн оролцохдоо шүүгчийн албан тушаалын нэр хүнд, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хүндэтгэн хадгалахыг чухалчилж, зан үйлээ эдгээр эрх ашигт хамгийн зохистой байдлаар нийцүүлэн зохицуулах шаардлагад захирагдана.

1.5. Шүүгчийн зан үйлийг шүүхэд ч, түүнээс өөр орчинд ч олон нийт сонжин ажиглаж байдаг. Үүний зэрэгцээ шүүгч хүн бусдын адил эрх, эрх чөлөөгөө эдэлж, хувийн амьдралаасаа таашаал авч амьдрахыг хүсэх нь зүйн хэрэг. Гэхдээ шүүгчийн албан тушаалд томилогдсоноор энгийн хүмүүсийн хувьд ердийн байж болох зарим зан үйлээс татгалзах хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөхөд хүрдэг. Тухайлбал, олон нийтийн мэдээллийн сүлжээнд оролцоходоо шүүгч илүү болгоомжтой байх шаардлагатай. Шүүгч албан үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэх, хувийн амьдралаа бусдын жишгээр авч явах эрх ашгийн тэнцвэр, заагийг ухамсарлаж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна.

Итгэл хүлээх ба нууц хадгалах

2.1. Шүүгч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ түүнтэй холбоотой нууц мэдээлэл хүлээн авч, нууцлалыг итгэмжлэн хадгалах хариуцлага хүлээдэг. Шүүн таслах ажиллагаа зарчмын хувьд нээлттэй, ил тод байх боловч зарим үйл баримт, баримт бичиг, бичлэг, хэргийн оролцогчдын талаарх хувийн мэдээлэл, хэрэг, маргаанд хамаарах тодорхой нөхцөл

байдал нь нууцын зэрэглэлд хамаардаг тохиолдол бий. Энэ тохиолдолд шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нууц мэдээллийг шүүгчийн албан үүрэгтэй холбоогүй өөр бусад зорилгод ашиглахгүй, задруулахгүй байх ёстой. Шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэхэд хэлэлцэж зөвлөлдсөн үйл баримтын нууцыг шүүгч задруулж болохгүй.

2.2. Шүүгч ажил хэргийн талаар бусадтай хэлэлцэж байхдаа ч албаны нууцтай холбоотой мэдээллийг санамсаргүй алдахаас болгоомжлох ёстой.

2.3. Шүүгчийн албан үүргийг гүйцэтгэхээ больсны дараа ч гэсэн тухайн үед хариуцаж байсан нууцыг үргэлжлүүлэн хадгалж, задруулахгүй байх үүргээс чөлөөлөгдөхгүй.

Эелдэг байх, хүндэтгэлтэй хандах

3.1. Шүүгч болон шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа бүх оролцогчид дор бүрнээ бусдын нэр төр, ажил хэргийн нэр хүнд шүүхийн ажиллагаанд бүхэлд нь хүндэтгэлтэй хандах ёстой. Шүүгч энэ нөхцөлийг бүрдүүлэхдээ шүүн таслах

ажиллагааны бүх оролцогчидтой эелдэг, хүндэтгэлтэй харьцах үүрэгтэй.

3.2. Шүүгчийн эелдэг, хүндэтгэлтэй хандлага зөвхөн шүүн таслах ажиллагаагаар хязгаарлагдахгүй бөгөөд шүүгч, ажлын хамтран зүтгэгчидтэйгээ, бусад хүмүүстэй харилцахдаа ч энэ байдлыг хадгалж хэвшсэн байх ёстой. Шүүгч бусдад тийнхүү эелдэг, хүндэтгэлтэй хандах нь шүүхэд хүндэтгэл төрүүлэх, түүнд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх талаар гаргаж байгаа хүчин чармайлт юм.

3.3. Зарим хэргийн нөхцөл байдал, өмгөөлөгч болон бусад оролцогчийн зүй бус үйлдэл зэргийн улмаас тэдгээр оролцогч шүүн таслах ажиллагааг өөрийн ашиг сонирхлын үүднээс урвуулан ашиглах, шүүн таслах ажиллагааны оролцогчидтой зохисгүй харьцахаас урьдчилан сэргийлэх, дэг журмыг сахиулах зорилгоор шүүгч хуулийн дагуу шийдмэг, шуурхай арга хэмжээ авахад хүрдэг. Энэ тохиолдолд шүүгч оролцогчдын эрхийг хангах болон шүүн таслах ажиллагааг үр нөлөөтэй, хуульд нийцүүлэн хэвийн явуулах эрх ашгийн хоорондын харьцааг зохистой баримтлах ёстой.

3.4. Шүүгч шүүн таслах ажиллагааны явцад бусдын үйлдлийн зөв бурууг үнэлж дүгнэх шаардлага гардаг боловч ямар ч тохиолдолд тухайн үйлдэл сэдлийн талаар зүй бус сэтгэл хөдлөлийн шинжтэй харилцаа хандлага гаргахаас сэрэмжилнэ.

3.5. Шүүгч шүүн таслах ажиллагааны оролцогчдод нүүрний хувирал, биеийн хэлэмж, үг хэллэг, бусад байдлаар тэднийг, эсхүл аль нэгийг нь үл тоомсорлох, тохуурхан даажигнах, дорд үзэх зэргээр зүй бус харилцаж байна гэх ойлголтыг төрүүлэхгүй байх ёстой.

Шүүхэд хандах ба өөрийгөө өмгөөлөх

4.1. Шүүгч шүүхэд хандах болон шүүхийн үйлчилгээг хэн бүхэнд хамгийн хүртээмжтэй байлгахад дэмжлэг үзүүлж, маргааныг шударга, үр дүнтэй шийдвэрлэх шүүхийн ба шүүхийн бус арга замуудын талаар хангалттай мэдлэгтэй байвал зохино.

4.2. Шүүгч идэвхгүй байдлаар төвийг сахих ба талуудад яг адилхан хандах нь тэр бүр тохиромжтой байдаггүй.

Талуудын зарим нь шүүхэд өөрийгөө төлөөлөн оролцдог. Шүүгч шүүхийн шударга байдал, шүүн таслах ажиллагааны үр нөлөөг алдагдуулахгүйн тулд хуулийн хүрээнд зарим оролцогчдод илүү идэвхтэй мэдээлэл өгч, зохих туслалцаа үзүүлэх шаардлагатай.

Бусадтай харилцах байдал

5.1. Шүүгч бусадтай зохистой харилцах нь шүүхийг хүндэтгэх, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй. Шүүгч бусдад, ялангуяа өөрийн удирдлага дор ажилладаг хүнд үг хэллэг, үйл хөдлөлөөрөө болон бусад байдлаар зохисгүй авир гаргаж болохгүй. Ийм үг, үйлдэл нь тухайн шүүгчийн төдийгүй нийт шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлнө.

5.2. Аливаа хэлбэрээр ажлын байрны дарамт үзүүлэхээс шүүгч ангид байх ёстой. Цаашлаад өөрийн албан тушаал, эрх мэдлээ зохисгүйгээр ашиглаж байна гэж ойлгогдохуйц байдлаар бусадтай харилцахаас зайлсхийнэ.

Албан тушаалын байдлаа урвуулан ашиглахгүй байх

6.1. Шүүгч албаны бүрэн эрхээ санаатайгаар урвуулан ашиглаж өөртөө болон бусдад эд материалын болон бусад давуу байдлыг олгож болохгүй.

Санхүүгийн харилцаанд оролцох хязгаарлалт

6.2. Шүүгч санхүүгийн харилцаанд оролцохдоо албаны бүрэн эрхээ ашиглах буюу бусдад ашиглуулах байдлаар хөрөнгө орлого арвижуулахад дэм үзүүлсэн аливаа үйл ажиллагаанд оролцохоос татгалзана.

Тодорхойлолт гаргах

6.3. Шүүгчид тодорхойлолт гаргуулахаар хүсэлт тавьж болно. Энэ тохиолдолд шүүхийн нэр хүндийг тухайн этгээдийн хувийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх, шүүгчтэй ойр дотно, давуу харилцаатай гэсэн сэтгэгдэл төрүүлэхээс зайлсхийх нь чухал юм. Шүүгч тодорхойлолт гаргахдаа тийнхүү тодорхойлолт гарган өгснөөр шүүгчийн албан тушаалын нэр

хүндэд сөргөөр нөлөөлөхгүй байх, шүүгч тухайн хүний талаар зөвхөн өөрийн хувийн байр суурийг илэрхийлэх, шүүгч тодорхойлолт гаргахаас татгалзсан тохиолдолд тухайн хүнд шударга бус болохгүй байхад анхаарна. Тодорхойлолт нь олон нийтэд ил болох магадлалтай бөгөөд нөхцөл байдал өөрчлөгдөн шүүгчийн гаргасан тодорхойлолт зохисгүй, эсхүл оновчгүй болсон гэж үзэх тохиолдолд шүүгч, шүүхийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үр дагаврыг урьдчилан тооцсон байх ёстой.

Хамтран ажиллагсдадаа дэмжлэг үзүүлэх

7.1. Шүүгч шүүхийн байгууллагад хамтран ажиллагсдадаа ёс зүйн зарчмыг сахин биелүүлэхэд дэмжин тусална. Хамтран ажиллагсад нь ёс зүйн зөрчил гаргах нөхцөл байдал бий болсон эсэхийг шүүгч анхаарч байх ёстой. Ёс зүйн зөрчил гаргах нөхцөл байдал анзаарагдсан тохиолдолд түүнийг таслан зогсоож, олон нийтийн итгэл алдагдахаас сэргийлнэ.

Гурав. УР ЧАДВАР, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛТЭЙ БАЙДАЛ

Агуулга

Шүүгч албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд хичээл зүтгэл гаргах ба мэргэжлийн ур чадварыг хангалттай эзэмшсэн байна.

Зарчим

1. Шүүгч шүүх хуралдаан даргалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах зэргээр шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхдээ өөрийн нөөц бололцоог бүрэн дайчилж ажиллана. Ийнхүү хичээл зүтгэл гаргахад саад болох аливаа үйл ажиллагаанд шүүгч оролцохгүй.

2. Шүүгч тухайн хэрэг, маргааны ээдрээ төвөгтэй байдал, тулгамдсан онцгой нөхцөл байдал зэргийг нарийвчлан тооцож үзсэний үндсэн дээр шүүн таслах ажиллагааг хуулиар тогтоосон хугацаанд нь аль болох шуурхай хэрэгжүүлнэ. Энэ зарчим нь шүүхийн шийдвэрийг бичгээр албажуулж гаргахад нэгэн адил хамаарна.

3. Шүүгч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадвараа дээшлүүлж өөрийгөө хөгжүүлэхийг эрмэлзэнэ.

4. Шүүгч шүүн таслах чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд ажил амьдралын эрүүл, зөв хэв маягийг баримтална.

Тайлбар

Нийтлэг зүйл

1.1. Хичээл зүтгэл нь шүүгч өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ур чадвартай, нягт нямбай, шуурхай, анхаарал болгоомжтой ажилласнаар илэрхийлэгдэнэ.

1.2. Шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүн таслах ажиллагааны бүхий л явцад хичээл зүтгэл, ур чадвараа дээд зэргээр дайчилна.

1.3. Шүүгч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс бусад үйл ажиллагаанд оролцохдоо шүүгчийн хараат бус, шударга байдлыг алдагдуулахгүй, албан үүргээ биелүүлэхэд саад учруулахгүй байх нөхцөл байдлыг тооцсон байна.

1.4. Шүүгчийн албан тушаалд томилогдсоноор бусад мэргэжлийн болон арилжаа, бизнесийн аливаа үйл ажиллагаанаас даруй татгалзана.

1.5. Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс шүүгчийг шүүхийн үйл ажиллагаанаас гадуурх үйл ажиллагаанд оролцуулахыг хүссэн тохиолдолд шүүхийн

хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр шийдвэрлэнэ. Шүүгчийн албан үүргийг гүйцэтгэхэд сөрөг нөлөө үзүүлэхээр байвал уг үйл ажиллагаанд оролцохгүй байвал зохино.

1.6. Шүүгчийн нэн тэргүүний үүрэг нь шүүх эрх мэдлийг хуульд нийцүүлэн зохих ёсоор хэрэгжүүлэх явдал юм. Энэ үүрэгтэй харшлахгүйгээр багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх боломжтой.

Цаг тухайд нь шийдвэрлэх

2.1. Шүүгч үүргээ биелүүлэхдээ хуулиар тогтоосон хугацааг баримтална. Шүүгч шүүн таслах ажиллагааг үр бүтээлтэй, шударгаар явуулж, шүүхийн шийдвэрийг аль болох шуурхай гаргахыг эрмэлзэнэ.

2.2. Шүүгч тухайн хэрэг, маргааныг илүү зардал, чирэгдэл гаргалгүйгээр, үр ашигтай, шуурхай шийдвэрлэхийн тулд бүх нөөц бололцоогоо дайчлан ажиллана.

Мэргэшлийн шаардлага

3.1. Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалахын тулд шүүгч

хангалттай мэдлэгтэй, сайтар мэргэшсэн байх ёстой.

3.2. Шүүгчийн мэдлэг, ур чадвар нь зөвхөн материаллаг болон процессын хууль тогтоомжоор хязгаарлагдахгүй илүү өргөн хүрээтэй байх бөгөөд үүний тулд мэргэжлийн үргэлжилсэн сургалтад тогтмол хамрагдаж байна.

3.3. Шүүгч нас, хүйс, арьс өнгө, шашин шүтлэг, соёл, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл зэрэг орчин үед хүний эрх чөлөөг хангахтай холбоотой онцлог асуудлын талаар шаардагдах сургалтад оролцоно.

3.4. Шүүгч шүүн таслах ажилд хэрэглэгдэх технологийн мэдлэгтэй байж, түүнийг саадгүй ашиглах чадварыг эзэмшсэн байна.

3.5. Шүүгч өөрийгөө хөгжүүлэхийн төлөө хичээл зүтгэл гаргана.

Эрүүл мэнд

4.1. Шүүгч албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэхийн тулд биеийн болон сэтгэцийн эрүүл мэнддээ байнга анхаарч, эрүүл байхын төлөө хүчин чармайлт гаргах ёстой.

Дөрөв. ТЭГШ БАЙДАЛ

Агуулга

Шүүгч шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу тэгш эрхийн зарчмыг хангахад зохистой байдлаар биеэ авч явна.

Зарчим

1. Шүүгч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шүүн таслах ажиллагааны аль ч оролцогчийг ялгаварлан гадуурхаж дорд үзэхгүйгээр бүгдэд тэгш, хүндэтгэлтэй хандана.
2. Шүүгч шүүн таслах ажиллагааны оролцогчид болон бусад хүмүүсийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахаас ангид байна.

3. Шүүгч шүүн таслах ажиллагааны явцад дүгнэлт хийхдээ хэвшмэл үзэл баримтлалд автаж болохгүй.

4. Шүүгч аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах үйл ажиллагаанд нэгдэж болохгүй.

Тайлбар

Нийтлэг зүйл

1.1. Тэгш байдлыг хангах хуулийн баталгаа нь нийгмийн гишүүдийг ялгаварлан гадуурхалтаас болон түүний сөрөг үр дагавраас хамгаалах зорилготой. Тэгш байдлыг хангах энэхүү баталгаа нь бүх хүмүүсийн нэр төрийг

хүлээн зөвшөөрч, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, арилгахад чиглэгдэнэ. Шүүгч арьс өнгө, нас хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн гарал, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, бэлгийн хандлага, нийгэм, эдийн засгийн болон бусад байдлаас үүссэн нийгмийн ялгаа, олон талт байдлын талаар шаардлагатай мэдлэг эзэмшсэн байна.

1.2. Тэгш байдал нь шударга ёсны үндэс суурь бөгөөд шүүхийн шударга байдал, шүүхэд итгэх олон нийтийн итгэлтэй нягт холбоотой. Шүүгч нь төвийг сахих ба тэгш байдлыг хангах талаар олон нийтийн итгэл, хүндэтгэл хүлээх хэмжээнд мэдлэг, чадвар эзэмшсэн байвал зохино.

Шүүн таслах ажиллагаанд тэгш байдлыг хангах

2.1. Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохдоо бусдад шударга бус хандах, ялгаварлан гадуурхах, тэгш бус байдлыг алдагдуулсан гэж ойлгогдохоор үг хэлж, үйлдэл гаргаж болохгүй. Шүүгч хайхрамжгүй хандаж,

оролцогчдыг үл хүндэтгэсэн шинжтэй дохио зангаа, ааш авир зэрэг бусад үйлдэл гаргахаас болгоомжилно.

2.2. Шүүгч олон нийтийн цахим сүлжээн дэх тэгш байдлыг алдагдуулсан шинжтэй аливаа үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийнэ.

2.3. Шүүхийн орчинд хүмүүст тэгш бус, ялгамжтай байдлаар харьцах буюу тийнхүү ойлгогдох харилцааг хүлээн зөвшөөрч болохгүй. Шүүн таслах ажиллагааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэн харьцахыг шаардана. Шүүгчийн санамсар, болгоомжгүй байдлаар хэлсэн үг, хошигнол нь бусдад таагүй байдлаар ойлгогдож, улмаар шүүн таслах ажиллагааны шударга байдалд эргэлзэх шалтгаан болж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Анхааралтай, хүлээцтэй сонсох нь шүүгчийн үүрэг хэдий ч, тэгш, зохистой байдлыг хангах шаардлага гарвал шүүх хуралдааны танхимд дэг сахиулах арга хэмжээ авна. Энэ нь тухайн нөхцөл байдлаас хамаарна.

Заримдаа эелдгээр залруулах нь хангалттай байдаг. Гэхдээ тодорхой зорилготой буюу түрэмгий үйлдлийг зогсоохын тулд нэмэлт арга хэмжээг авна.

2.4. Шүүгч өөрийн удирдлагад хамаарах шүүхийн ажилтнууд болон өөр бусад хүний зүгээс хэргийн оролцогчдыг ялгаварлаж харьцсан, үл хүндэтгэсэн, тэгш байдлыг алдагдуулсан шинжтэй үйлдлийг зөвшөөрч болохгүй.

Баригдмал үзэл, хандлагаас зайлсхийх

3.1. Шүүгч аливаа хүний зан авир, үйл явдлын талаар дүгнэлт хийхдээ баригдмал үзэлд үндэслэж болохгүй. Баригдмал хандлага нь хууль хэрэглэх явцад бодит байдлын талаар төөрөгдөл үүсгэж, алдаа гаргах шалтгаан болдог.

3.2. Баригдмал үзэл, хандлагад хамааралтай байх нь ихэвчлэн санаатай бус хэд хэдэн шалтгаантай байх боломжтой. Нэг талаас шүүгч аливаа тайлбар, үндэслэл

гаргахад баригдмал үзэл хандлага нөлөөлсөн гэдгийг өөрөө ухаараагүй байж болно. Нөгөө талаас, шүүгч хэргийн оролцогчийн зан үйл соёлын ялгааны учир холбогдлыг сайтар ойлгоогүй байж болно.

3.3. Шүүгч хараат бус байдлаа хадгалах, тэгш байдлын зарчмыг хангахын тулд баригдмал үзэлд автахгүй байх үүднээс нийгэм, соёлын ялгаатай байдал, түүнтэй холбоотой амьдралын зан үйлийн олон талт байдлын талаар өөрийнхөө мэдлэг, ойлголтыг байнга хөгжүүлэн тэлж байх ёстой.

Ялгаварлан гадуурхах үйл ажиллагаанд нэгдэхгүй байх

4.1. Шүүгч арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, бусад байдлаар ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа явуулдаг аливаа байгууллагад гишүүнчлэлтэй байж болохгүй. Үүний адилаар ялгаварлан гадуурхах шинжтэй үйл ажиллагаа явуулдаг гэдгийг мэддэг бол тийм газарт уулзалт, үйл ажиллагаа явуулахаас зайлсхийнэ.

Тав. ТӨВИЙГ САХИХ БАЙДАЛ

Агуулга

Шүүгч шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төвийг сахих бөгөөд энэ нь бусдад ойлгогдохоор байх ёстой.

Зарчим

1. Шүүгч нь шүүгчээр ажиллах хугацаандаа шүүгчийн болон шүүх эрх мэдлийн төвийг сахисан байдалд итгэх итгэлийг хадгалах, бэхжүүлэх зорилгод нийцүүлэн биеэ авч явна.
2. Шүүгч төвийг сахисан байдалд нь эргэлзээ төрүүлэхүйц зан байдлаас зайлсхийнэ.
3. Шүүгч албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх, эрх ашгийн зөрчил үүсгэхээс сэргийлнэ.

4. Шүүгч төвийг сахисан байдлаа хадгалахын зэрэгцээ олон нийтийг болон хууль зүйн мэргэжлийн салбарыг эрх зүй, шүүхийн хараат бус байдал, шүүхийн болон шүүгчийн гүйцэтгэдэг үүрэг, шүүн таслах ажиллагааны талаарх мэдээллээр хангах, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх талаар хүчин чармайлт гарган ажиллана.

5. Шүүгчээр ажиллаж байсан хүн шүүхийн нэр хүндийг дордуулах, шүүгчийн хараат бус, шударга, төвийг сахисан байдлын талаарх олон нийтийн итгэл, хүлээлтийг бууруулах шинжтэй аливаа үйлдэл гаргахаас зайлсхийвэл зохино.

Тайлбар

Нийтлэг зүйл

1.1. Төвийг сахиж, хараат бус байх нь хууль дээдлэх ёсны суурь ойлголт юм. Төвийг сахих байдал нь шүүхийн үндсэн шинж, шүүгчийн гол шалгуур болно.

1.2. Төвийг сахих нь өрөөсгөл дүгнэлт хийх, аль нэг талыг баримтлахгүй байхыг шаарддаг. Шүүгч төвийг сахихаас гадна тийнхүү төвийг сахиж байна гэж энгийн иргэнд ойлгогдох нөхцөл байдлыг бүрдүүлнэ.

Шүүгчийн үүрэг

1.3. Шүүгчийн үндсэн үүрэг нь төвийг сахих ба төвийг сахиж байна гэж тийнхүү ойлгогдох явдал юм. Шүүгч төвийг сахирын тулд талуудад шударга, тэгш, алагчлалгүй хандаж, олон талын үзэл баримтлал, итгэл үнэмшлийг нээлттэй, чөлөөтэй харьцуулан дүгнэнэ.

1.4. Шүүгч бусдад аливаа хэлбэрээр давуу байдал олгох, шударга бус хандах, эсхүл ялгаварлан гадуурхах байдал гаргахгүйгээр албан үүргээ хэрэгжүүлнэ. Шүүгч бусдыг алагчилж, ялгавартай байдлаар харьцвал шүүхэд итгэх олон

нийтийн итгэлийг алдагдуулна. Тиймээс шүүгч шүүхийн шийдвэрт гаднын зүй бус нөлөө орсон гэх хардлага төрүүлэх үйлдэл гаргаж болохгүй.

1.5. Шүүгч аливаа хөдөлгөөн, үзэл суртлыг дэмжих буюу үгүйсгэх ойлголт төрүүлэхүйц үг, хэллэг ашиглах, хувцас хэрэгсэл өмсөх зэргээр шүүгчийн төвийг сахих байдлыг алдагдуулахуйц байдал гаргаж болохгүй. Энэ шалтгаанаар шүүгч шүүн таслах ажиллагаанд нөлөөлөхүйц аливаа мэдэгдэл, байр суурь илэрхийлэх, тодорхой дүрслэл бүхий бэлгэдлийг дэмжихээс зайлсхийнэ.

1.6. Шүүгч шүүн таслах ажиллагааг хуульд заасан журмын дагуу үр ашигтай явуулах нөхцөлийг хангаж, шүүхийн үйл ажиллагааг хэн нэгэнд ашигтайгаар урвуулан ашиглах боломжийг бүрдүүлэхгүй байх ёстой. Энэ үүргээ хэрэгжүүлэхийн тулд шийдэмгий арга хэмжээ авах шаардлага үүсэж болно.

1.7. Шүүгч хууль ёсны төлөөлөгчтэй эсэхээс үл хамааран хэргийн оролцогч болон бусад хүмүүст шүүхийн үйл явцыг бүрэн ойлгох, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгоно. Шүүхэд өөрийгөө төлөөлж буй зарим

хүмүүс өөрсдийн эрх, үүрэг, үйл ажиллагааны үр дагаврын талаар хангалттай мэдээлэлгүй байх тохиолдолд шүүгч төвийг сахих зарчмын үүднээс тэдний эрх ашигт хохирол учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Энэ нь талууд өөр хоорондоо шударга байх, төвийг сахих байдлыг алдуулахгүй байдлаар хэрэгжих ёстой.

1.8. Шүүгч өөрийгөө төлөөлж буй хэргийн оролцогчид зохих туслалцаа үзүүлэх нь эсрэг талуудад сөрөг ойлголт төрүүлж болзошгүй. Өөрийгөө төлөөлж буй хэргийн оролцогчдод тусламж үзүүлэхдээ нөгөө талд шударга бус гэж ойлгогдох нөхцөлийг бүрдүүлж болохгүй. Нэг талыг баримталж байна гэх хардлага төрүүлэхээс байнга зайлсхийж бүх талтай тодорхой, ил тод харьцах шаардлагатай.

1.9. Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэхэд шүүгч чухал үүрэг гүйцэтгэнэ. Маргааныг ийнхүү шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо шүүгч дараах нөхцөлийг харгалзан үзэх нь чухал. Үүнд: (I) үйл явц ба үр дүнг талууд өөрсдөө хүлээн зөвшөөрөх, (II) үр дүн нь талуудын гаргасан шийдвэрт үндэслэсэн байх (III) үйл явц нь талуудад ил

тод байх, (IV) албадлагаар, эсхүл тодорхой ойлголтгүйгээр, хууль бусаар үр дүнд хүрээгүй байх, (V) гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй байх. Шүүгч дээрх бүх нөхцөл байдлыг харгалзан төвийг сахисан байр сууринаас хандана.

Хязгаарлалт

2.1. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх үүднээс шүүгчийн иргэний эрх, эрх чөлөөнд зарим хязгаарлалт тавигддаг. Шүүгч олон нийтийн харилцаанд оролцохдоо дараах хоёр асуудалд онцгой анхаарна. Нэгд, шүүгчийн төвийг сахих байдалд ямар нэг байдлаар хохирол учруулахгүй байх, хоёрт шүүгчийн албан тушаалын нэр хүндэд харшлахаар шүүмжлэлд өртөх нөхцөл бүрдүүлэхгүй байх ёстой.

Улс төрийн үйл ажиллагаа

2.2. Шүүгчээр томилогдсон үеэс улс төрийн бүх төрлийн үйл ажиллагаанаас татгалзана. Ийнхүү татгалзахаас гадна улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцоогүй гэдэг нь энгийн хүмүүст

ойлгогдохоор байна. Үүний тулд дараах үйл ажиллагаанаас татгалзана: (I) улс төрийн намын гишүүнчлэлтэй байх, улс төрийн намыг санхүүжүүлэх, (II) улс төрийн хурал, цуглаан, улс төрийн санхүүжилттэй үйл ажиллагаанд оролцох, (III) улс төрийн намын сонгуулийн ажиллагаанд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх, (IV) улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, (V) улс төрийн маргаан, мэтгэлцээнд оролцох.

2.3. Шүүгчийн гэр бүлийн гишүүн улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй байх тохиолдолд тэр нь шүүгчийн төвийг сахих байдалд нөлөөлж болохыг ухамсарлах ёстой. Энэ тохиолдолд шүүгч тухайн үйл ажиллагаатай холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэхээс татгалзана.

Олон нийтийн цахим сүлжээ

2.4. Шүүгчийн цахим сүлжээнд хийж буй үйлдэл өөрт нь болон шүүх мэдлийн талаар ямар төсөөлөл үлдээх эсэх шүүн таслах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хэрхэн нөлөөлөх зэрэгт хянамгай хандвал зохино. Түүнчлэн шүүгч өөрийн гэр бүлийн

гишүүддээ цахим сүлжээнд явуулж буй аливаа үйл ажиллагаа нь шүүгчид сөргөөр нөлөөлж болзошгүйг сануулж, анхааралтай, хянамгай байх хэрэгтэй.

2.5. Олон нийтийн цахим сүлжээ ашиглах тохиолдолд ямар харилцаа холбоо, сүлжээнд орж байгаа, түүний дотор ямар асуудлыг дэмжих, эсхүл няцаах байр суурь илэрхийлж буйгаа анхаарвал зохино.

2.6. Шүүгч олон нийтийн цахим сүлжээг зохистой ашиглахтай холбоотойгоор үйл ажиллагаа, хэрэглээ, аюулгүй байдал, хувийн нууцлалын тохиргоог мэддэг байх ёстой.

2.7. Шүүгч хэргийн оролцогч, гэрч, эсхүл шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны талаар мэдээ, мэдээллийг шүүхээс гадуур, өөрөө олж авах, хүлээн авахаас зайлсхийнэ. Ийм тохиолдол үүсвэл шүүгч уг асуудлыг шударга ёсны зарчимд нийцсэн байдлаар зохистой арга замаар шийдвэрлэнэ.

Бэлэг, уратшуулал

2.8. Шүүгч өөрөө болон бусдаар дамжуулан шүүн таслах ажиллагаатай холбоотойгоор

ямар нэг үйлдэл хийсний, хийхийн, эсхүл хийхгүй байхын төлөө бэлэг, шан харамж, зээл авах, давуу байдал олгохыг хүсэхийг цээрлэнэ. Шүүгч хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгчид шүүн таслах үйл ажиллагаанд тодорхой ашиг сонирхол бүхий бусад этгээдээс бэлэг, урамшуулал авч, хөнгөлөлт эдлэхээс татгалзана. Шүүгч өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах бусад хүмүүст дээрх үйлдэл хийхийг зөвшөөрөх, хийснийг мэдсэн бол эвлэрэн өнгөрөөж болохгүй.

Үг хэлэх, хуралд оролцох

2.9. Шүүгч бусдад мэдлэг, мэдээлэл түгээх, сургалтын үйл ажиллагаанд оролцох нь шүүхийн нэр хүндэд төдийгүй олон нийтэд үр өгөөжтэй байдаг. Түүнээс гадна шүүгч нь өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагадаа тулгуурлан тодорхой арга хэмжээнд илтгэгчээр оролцох нь ерөнхийдөө шүүхийн нэр хүндэд эерэг нөлөөтэй байдаг. Гэхдээ олон нийтийн өмнө илтгэх нь шүүгчийн төвийг сахих байдлын талаарх олон нийтийн ойлголт, төсөөлөлд сөрөг нөлөөлөх эрсдэл дагуулах магадлалтай тул хянамгай хандвал зохино. Хэрэв шүүгчид ийм арга хэмжээнд

оролцож илтгэл тавих боломж гарсан бол дараах хүчин зүйлсийг харгалзан оролцох эсэх болон оролцсон тохиолдолд ямар агуулгаар илтгэхээ шийдэх хэрэгтэй. Үүнд (I) шүүгчийг урьж байгаа байгууллага, (II) хүрэлцэн ирэх зочид, оролцогчид, (III) илтгэлдээ хөндөж ярих сэдэв, агуулга, (IV) ярих сэдэв, агуулгын шүүх, шүүгчтэй холбогдох байдал, (v) ярих сэдэв, агуулгын улс төрийн бодлого, олон нийтийн шүүмж дагуулсан сэдэвтэй холбогдох байдал, (VI) шүүгчийн ярьсан зүйлсийг бичлэг болгон хадгалах, олон нийтэд түгээх магадлал, (VII) шүүгчийн ярих зүйлсийн оролцогчдод мэдээ мэдээлэл хүргэх, тэднийг сургаж хөгжүүлэхэд оруулах хувь нэмэр. Шүүгч эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзэж, эргэлзээ төрвөл ерөнхий шүүгч болон зөвлөн туслах бусад итгэл бүхий этгээдэд хандаж, зөвлөмж хүсэж болно.

Арга хэтжээнд оролцох

2.10. Шүүгч нийгмийн болон олон нийтийн арга хэмжээ, хуралд оролцох нь тэдний төвийг сахих байдалд сөргөөр нөлөөлөхгүй, арга хэмжээний мөн чанар, зохион байгуулагч тал нь ёс зүйн шаардлагад

харшлах аливаа асуудал үүсгэхгүй гэсэн итгэлтэй байгаа тохиолдолд оролцож болно.

2.11. Шүүгчийн оролцох хурал, чуулганы үйл ажиллагааны ивээн тэтгэгч, тухайн арга хэмжээний мөн чанар, цар хүрээ нь шүүгч төвийг сахихгүй байна гэсэн ойлголтыг энгийн хүнд төрүүлэхээргүй байх ёстой.

2.12. Шүүгч бизнесийн байгууллагын санхүүжүүлж буй хурал зөвлөгөөн болон бусад арга хэмжээнд оролцох нь таагүй асуудал дагуулж болзошгүй байдаг. Уригдсан тохиолдолд тухайн арга хэмжээг зохион байгуулж буй байгууллага, мөн тухайн арга хэмжээнд уригдсан зочид, шүүгчийг урих болсон шалтгаан, уг арга хэмжээнд оролцсоноор шүүгчийн талаарх олон нийтийн төсөөлөлд үзүүлж болох сөрөг үр дагавар зэргийг шүүгч судалж, сайтар тооцож үзэх шаардлагатай.

2.13. Хуулийн мэргэжлийн салбарын, түүний дотор хууль зүйн зөвлөгөө өгөх байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд уригдсан дээрх нөхцөл байдлуудаас гадна зохион байгуулагч болон оролцогчидтой өмнө хувийн

ямар харилцаатай байсан, уг арга хэмжээнд оролцсоноор шүүгч, шүүх, зочноор урьсан байгууллага, өмгөөлөгч, хуульчдын хооронд дараа нь ямар нөхцөл байдал үүсэж болох талаар цэгнэж үзэх нь зүйтэй. Арилжааны болон бизнесийн ашиг сонирхлын зорилготойгоор, эсхүл үйлчлүүлэгчиддээ шүүгчтэй ойр дотно харилцаатай гэж харуулах зорилготой байгаа нь мэдэгдвэл шүүгч оролцохоос татгалзах хэрэгтэй.

Ашиг сонирхлын зөрчил

3.1. Ёс зүйн хөтчид ашиг сонирхлын зөрчлийн тухай тусгаж байгаа нь шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулахтай холбоотой хуулийн зохицуулалтыг тайлбарлах зорилгогүй. Харин шүүгчийн хувийн ашиг сонирхол нь шүүгчийн албаны үүрэг хариуцлагатай зөрчилдсөн гэж бусад хүмүүс үзэж болох нөхцөл байдлыг тодорхойлж, үнэлэхэд чиглүүлэх зорилготой. Шүүгч өөрт хуваарилагдсан хэргийг шударга ёсыг хангах ёстойгоо бүрэн ухамсарласны үндсэн дээр, хянан шийдвэрлэх үүрэгтэй.

3.2. Шүүгчийн буюу түүнтэй ойр дотно хэн нэгний хувийн ашиг сонирхол нь шүүгчийн төвийг сахин шийдвэр гаргах үүрэгтэй зөрчилдөх үед ашиг сонирхлын зөрчил үүсдэг. Шүүгчийн төвийг сахих байдал нь шүүгч төвийг сахин ажиллахаас гадна энгийн иргэнд тийнхүү ойлгогдохтой холбоотой. Иймд шүүгч өөрийн хувийн ашиг сонирхол ба шүүн таслах ажиллагааг төвийг сахиж хэрэгжүүлэх албаны үүрэг хооронд үүсэж болзошгүй аливаа зөрчлөөс зайлсхийх ёстой.

3.3. Шүүгчийн ашиг сонирхлын зөрчил ихэвчлэн дараах тохиолдолд үүсдэг. Үүнд: бусдаас төрөл бүрийн ашиг хүртэх; шүүн таслах ажиллагааны оролцогчтой гэр бүлийн болон хувийн өөр харилцаатай байх; шүүн таслах ажиллагааны оролцогч болон хянан шийдвэрлэж буй асуудлын талаар шүүгч хувийн байр сууриа илэрхийлэх.

3.4. Шүүгчээр томилогдсон даруйдаа өмгөөлөх, хуулийн зөвлөгөө өгөх ажлыг даруй зогсоож, арилжаа, бизнесийн үйл ажиллагаанаас татгалзаж, өмнө эрхэлж байсан ажил, бизнестэй ашиг сонирхлын ямар ч холбоогүй болсон байх ёстой.

3.5. Шүүгч бусад иргэдийн адил нийтлэг байдлаар санхүүгийн ба эд хөрөнгийн харилцаанд оролцох нь зөрчил болохгүй бөгөөд даатгалтай байх, банкны данстай байх, зээлийн карт ашиглах, нийтээрээ эзэмшдэг аж ахуйн нэгжид үнэт цаас эзэмших нь шүүн таслах ажиллагаатай ямар ч хамааралгүй бол ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй.

Батлан даагч

3.6. Шүүн таслах үүргээ биелүүлэхэд саад учруулж болзошгүй тул зайлшгүй тохиолдолд буюу шүүгч гэр бүл, үр хүүхэд, төрөл саднаас бусад хүний хувьд батлан даагчийн үүрэг гүйцэтгэхээс зайлсхийх ёстой. Ялангуяа батлан даасныхаа төлөө хөлс, урамшуулал авах ёсгүй.

Хуучин танил, хувийн харилцаа

3.7. Шүүгчийн танил талын харилцаа нь энгийн иргэнд шүүгчийн төвийг сахих байдлын талаар эргэлзээ төрүүлэхүйц байгаа эсэхэд мэдрэмжтэй байх ёстой. Тодруулбал, шүүгчийн өмнөх үйлчлүүлэгч, хуулийн зөвлөгөө өгөх газрын ажилтнууд, төрийн байгууллагын, албан хаагчидтай

холбоотой хэрэг маргаан гарч болно. Энэ тохиолдолд нөхцөл байдлыг дараах хүчин зүйлүүдийг харгалзан үнэлэх ёстой. Үүнд: (I) өмнө ажиллаж байсан байгууллагад холбогдох хэргийг хянан шийдвэрлэхгүй байх, (II) өмнө нь хамтран ажиллаж байсан хуучин танил хүмүүст холбогдох хэргийг хянан шийдвэрлэхгүй байх. (Шүүгч гэр бүлийн гишүүн, дотнын найз нь ажилладаг өмгөөллийн байгууллагын оролцож байгаа хэргийг шүүн таслахаас зайлсхийнэ.

Санхүүгийн хүндрэл

3.9. Шүүгч өөрт учирсан санхүүгийн хүндрэлийг даван туулах арга замыг эрэлхийлэхдээ ашиг сонирхлын зөрчил гэж бусдад ойлгогдох арга замыг сонгож болохгүй. Ийм нөхцөлд хэрэв шүүгчийн санхүүгийн хүндрэлээ шийдвэрлэсэнтэй холбоотой ямар нэг маргаан үүсэж, шүүгч өөрөө шүүхэд хэргийн оролцогч, гэрч болох тохиолдол үүсэх эсэх талаар урьдчилан бодож тооцсон байх учиртай.

Ашиг сонирхлын зөрчлийг тайлбарлах

3.10. Зарим тохиолдолд шүүгч гарч болзошгүй ашиг сонирхлын

зөрчлийн талаар талуудад тайлбарлаж, саналыг нь сонсох нь зүйтэй. Талууд зөвшөөрсөн ч гэсэн шүүхийн төвийг сахих зарчмыг хэрэгжүүлэх үндсэн хариуцлага шүүгчид ногдоно.

Олон нийтийн боловсрол

4.1. Шүүгч өөрийн эрх хэмжээний хүрээнд болон түүнээс гадуур эрх зүйн тогтолцоог сайжруулах, шударга ёсыг сахиулахад хувь нэмэр оруулах нийтлэг үүрэгтэй. Энэ хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажил, сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжтой. Шүүгчид тавих хязгаарлалтад хамаарахгүй бол оюутан, хуульч, шүүгч зэрэгт зориулсан хууль зүйн сургалтын хөтөлбөрт оролцох, лекц унших, загвар шүүх хуралдаанд оролцох, хууль зүйн чиглэлээр илтгэл, өгүүлэл бичих зэргээр хууль тогтоомж болон хуулийн дагуу явагдах үйл ажиллагааг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох үйл хэрэгт оролцож болно.

4.2. Энэ ажиллагаа нь шүүгчийн шүүн таслах ажиллагааг цалгардуулахгүй, ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөхгүй байх ёстой.



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

Утас: 70140459

Вэб хаяг: www.munkhiin-useg.mn